



ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны
7 дугаар сарын 07-ны өдрийн R-2023-40 дүгээр тогтоолын
1 дүгээр Хавсралт



ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ
АУДИТЫН ХОРООНЫ ДҮРЭМ

ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

Хувилбар	3.0
Батлагдсан огноо	2015 оны 3 дугаар сарын 25-ны өдөр
Шинэчилсэн огноо	2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр
Нэмэлт, өөрчлөлт оруулж, шинэчлэн баталсан огноо	2023 оны 7 дугаар сарын 07-ны өдөр
Шинэчлэх дараагийн огноо	2026 оны 3 дугаар сар
Баталсан эрх бүхий байгууллага	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Боловсруулсан	Ерөнхий Аудитор
Холбогдох эрх зүйн баримт бичиг	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн үйл ажиллагааны журам
Хамрах хүрээ	ХасБанкны хүрээнд
Холбогдох код	
Хувилбар 1.0	ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны 2015 оны 3 дугаар сарын 24-ны өдөр гаргасан зөвлөмж болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2015 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн ээлжит хурлаар хэлэлцэж батлав.
Хувилбар 2.0	Монголбанкны холбогдох журам болон Дотоод Аудиторын Хүрээлэнгийн (IIA) Олон улсын мэргэжлийн практикийн хүрээ (IPPF) стандартад нийцүүлэн хянав.
Хувилбар 3.0	Санхүүгийн Зохицуулах Хорооны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолоор баталсан Компанийн Засаглалын Кодекс, Монгол Улсын Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд нийцлүүлэн хянав.

АГУУЛГА

1. НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОРИЛГО.....	3
2. ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	3
3. ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА.....	4

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ХОРООНЫ ЗОРИЛГО

- 1.1. ХасБанк (цаашид "Банк" гэх)-ны Аудитын Хороо (цаашид "Хороо" гэх) нь дор дурдсан хяналтын үүргийг хэрэгжүүлэх замаар хувьцаа эзэмшигчид, боломжит хувьцаа эзэмшигчид, зээлдүүлэгчид, хөрөнгө оруулагчдын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-д дэмжлэг үзүүлнэ. Үүнд:
 - а) Банкны хууль тогтоомжийн шаардлагын нийцэл;
 - б) Хөндлөнгийн аудиторын ур чадвар, хараат бус байдал;
 - в) Банкны дотоод аудитын үйл ажиллагааны гүйцэтгэл;
 - д) Дотоод болон хөндлөнгийн аудитын тайлан, удирдлагын захидлыг хүлээн авч шаардлагатай бол аудитортой уулзаж, аудиторын зөвлөмжид хариу өгөх;
 - е) Банкны дотоод хяналтын тогтолцоо.
- 1.2. Хорооны үйл ажиллагааг зохицуулахтай холбоотой бусад харилцааг ТУЗ-ийн дотоод журмын дагуу зохицуулна.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ХОРООНЫ БҮТЭЦ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

- 2.1. Хорооны бүх гишүүд санхүүгийн мэдлэгтэй, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан санхүүгийн менежментийн туршлага бүхий байна. Гишүүдийн бүрэлдэхүүнд нь хүйсийн тэгш байдлыг хангах эсхүл Санхүүгийн Зохицуулах Хорооноос баталсан Компанийн Засаглалын Кодекст заасан аль нэг хүйсийн эзлэх доод хэмжээг хангахыг эрмэлзэнэ.
- 2.2. Хорооны гишүүн нь өөр компани эсхүл банкны ТУЗ-ийн гишүүнээр ажиллахгүй ба хэрэв ажиллахаар бол энэ талаар ТУЗ-д урьдчилан мэдэгдэх бөгөөд давхар ажиллах нөхцөл нь тухайн гишүүний Аудитын хороонд ажиллах ажлын үр дүнд нөлөөлөхгүй байна.
- 2.3. Хороо нь Дотоод аудитын нэгжийн дүрэм, бодлогыг хянан ТУЗ-д батлуулахаар зөвлөмж болгоно.
- 2.4. ТУЗ-ийн хараат бус гишүүн Хороог даргалах бөгөөд ТУЗ-ийн даргын албан тушаалыг хавсран гүйцэтгэхийг хориглоно. Хорооны дарга нь сүүлийн гурван жилийн хугацаанд үйлчилгээ үзүүлж буй хөндлөнгийн аудитын компанид ажиллаж байгаагүй байх шаардагатай.
- 2.5. Банкны гүйцэтгэх удирдлага, ажилтнуудыг зөвхөн тус Хорооны хүсэлтээр хуралдаанд оролцуулна.
- 2.6. Дотоод аудитын бодлого, Хорооны дүрэм, түүний бүтэц, хурлын давтамж, гишүүдийн оролцоог Банкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд тухай бүр тогтмол мэдээлнэ.
- 2.7. Банкны гүйцэтгэх удирдлагын гишүүнийг Хорооны гишүүнээр томилохыг хориглоно.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ҮҮРЭГ, ХАРИУЦЛАГА

3.1. Энэхүү дүрмийн 1 дүгээр зүйлд заасан зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд Хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Түүнчлэн Хороо нь ТУЗ-өөс шилжүүлсэн бусад үүргийг гүйцэтгэнэ.

А. Санхүүгийн тайлан ба дотоод хяналт

- а) Хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан Банкны жилийн санхүүгийн тайлангуудыг ТУЗ-д танилцуулахаас өмнө аливаа материаллаг асуудал болон "Удирдлагын захидал"-д тусгасан тодруулгуудын талаар банкны гүйцэтгэх удирдлага болон хөндлөнгийн аудиторуудтай уулзаж, тодруулах, хянах.
- б) Монгол Улсын Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Банкны зохистой удирдлагыг хэрэгжүүлэх тухай зөвлөмж болон энэ дүрмийн хүрээнд баталсан аливаа чиг үүргийг хэрэгжүүлэх.
- в) Нягтлан бодох бүртгэл болон санхүүгийн тайлагналын голлох асуудлууд, тэр дундаа комплекс эсхүл тогтмол хийгддэггүй гүйлгээ, олон талт байр сууриас тайлбарлаж болохуйц хэсгүүдийг хянах, мэргэжлийн болон зохицуулалтын сүүлийн үеийн мэдэгдлүүд зэрэг санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг ойлгох.
- г) Удирдлага болон хөндлөнгийн аудиторуудын хооронд санхүүгийн тайлагналын талаарх санал зөрөлдөөнийг зохицуулахад дэмжлэг үзүүлэх.
- д) Банкны дотоод хяналтын үр ашигтай байдалд банкны жилийн болон хагас жилийн санхүүгийн тайлан, мэдээллийн технологийн аюулгүй байдал, хяналтыг харгалзан үзнэ.
- е) Дотоод болон хөндлөнгийн аудитаас банкны санхүүгийн тайлагналын үйл ажиллагааны дотоод хяналтад хийсэн шалгалтын хамрах хүрээг ойлгож, аудитын тайланд тусгагдсан эрсдэл өндөртэй асуудлууд, өгөгдсөн зөвлөмж болон удирдлагын хариу тайлбаруудыг гаргуулан авах.

В. Хөндлөнгийн аудитор

- а) Хороо нь хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалт, гэрээг үргэлжлүүлэн сунгах, дуусгавар болгох зэрэг асуудлыг ТУЗ-д зөвлөмж болгон батлуулах бөгөөд дотоод аудит болон худалдан авалт хариуцсан нэгжтэй зөвшилцөн хөндлөнгийн аудиторуудын үйлчилгээний хөлсийг тохиролцоно. Санхүүгийн аудитын хамгийн өндөр стандартыг хангахын тулд хөндлөнгийн аудиторыг сонгохдоо хатуу шалгуурыг баримтална. Эдгээр шалгуурт компанийн нэр хүнд, мэргэшсэн байдал, салбарын туршлага, аудитын үйл ажиллагаа нь компанийн шаардлагад нийцэж байгаа эсэх зэрэг багтах хэдий ч үүгээр хязгаарлагдахгүй юм. Хөндлөнгийн аудиторыг сонгон шалгаруулах үйл явцыг сонгон шалгаруулах үед мөрдөгдөж буй худалдан авах ажиллагааны бодлогод нийцүүлэн хийнэ. Тус бодлого нь компанийн стратегийн ашиг сонирхолд нийцсэн шударга, өрсөлдөөнтэй, ил тод сонгон шалгаруулах үйл явцыг хангах тогтолцоог бүрдүүлдэг.
- б) Аудитын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангахын тулд хөндлөнгийн аудитор хараат бус байх нь чухал юм. Аудитын хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэлүүдэд ашиг сонирхлын зөрчил, аудитын бус үйлчилгээ үзүүлэх, аудитын нэг

компанийг удаан хугацаагаар ажиллуулах, эсвэл компани болон хөндлөнгийн аудиторын хоорондох санхүүгийн болон хувийн харилцаанаас үүдэж болно.

Эдгээр болзошгүй эрсдлийг удирдахын тулд Хороо дараахь асуудалд анхааралтай хандана, үүнд:

Ашиг сонирхлын зөрчил: Банк болон хөндлөнгийн аудитор нь ашиг сонирхлын зөрчил үүсгэж болзошгүй аливаа харилцаа, үйлчилгээг ил болгох ёстой. Аудитын хараат бус байдлыг хангахын тулд эдгээр нөхцөл байдлыг үнэлж, зохих ёсоор удирдана.

Аудитын бус үйлчилгээ: Хөндлөнгийн аудитын хараат бус байдлыг алдагдуулахгүйн тулд аудитын бус үйлчилгээ үзүүлэх хүрээг хязгаарлана. Одоогийн гэрээний үнийн дүнгийн 25% хүртэлх үнийн дүн бүхий аудитын бус үйлчилгээ авах тухай шийдвэр гаргах эрх нь гүйцэтгэх удирдлагын багт хадгалагдана, үүнээс бусад үйлчилгээ авах бол Хороогоор урьдчилан шийдвэрлүүлсэн байна.

Аудиторын ажиллах хугацаа: Компани нь аудитын хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд хөндлөнгийн аудиторыг тогтмол солих асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

Ил тод байдал: Компани нь хөндлөнгийн аудитортой харилцах харилцаа, хамтран ажиллах гэрээний ил тод байдлыг дэмжиж ажиллана. Аудитын хараат бус байдалд учирч болзошгүй эрсдэлийг Хороонд мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.

- c) Хороо нь хөндлөнгийн аудитын санал болгох бүх төрлийн аудитын үйлчилгээ буюу аудитын хамрах хүрээ, арга аргачлал зэргийг хянан батлахдаа дотоод аудитын ажлын уялдааг харгалзан үзнэ.
- d) Хөндлөнгийн аудиторуудын мэргэшил, гүйцэтгэл, хараат бус байдлыг жилд нэгээс доошгүй удаа үнэлнэ.
- e) Хороо нь шаардлагатай гэж үзсэн асуудлаар хөндлөнгийн аудитортой тусгайлан тогтмол уулзаж байна.
- f) Хороо нь дараахь асуудлаар хөндлөнгийн аудиторын хамт хяналтыг хэрэгжүүлнэ. Үүнд: (1) аудит хийх явцад тулгарсан аливаа асуудал болон хүндрэл, аудитын хамрах хүрээг тогтооход үүссэн бэрхшээл, хамрах хүрээнд багтах шаардлагатай мэдээлэл олж авахад тавигдсан хязгаарлалт, хандах боломжгүйд хүрсэн нөхцөл байдал; (2) аудит болон гүйцэтгэх удирдлага хооронд үүссэн томоохон санал зөрөлдөөн; (3) дээрх асуудалд хандаж буй гүйцэтгэх удирдлагын хариу арга хэмжээ зэрэг хамаарна.
- g) Хөндлөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгнө.

С. Дотоод аудит

- a) Хороо нь Ерөнхий Аудиторыг томилно.
- b) Хороо нь Дотоод аудитын дүрэм, бодлого, жилийн төлөвлөгөө, төсөв, орон тоо, дотоод аудитын үйл ажиллагааны журам, бүтцийг батлах бөгөөд дотоод аудитын

мэргэжлийн үйл ажиллагааны стандартад нийцэж байгаа эсэхийг хянаана. Дотоод аудитын бүтэц, бүрэлдэхүүн, дотоод аудитын чиг үүргийн талаарх мэдээлэл, баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг банкны цахим хуудсаар тухай бүр нийтэд мэдээлнэ.

- c) Хороо нь дотоод аудитуудын хараат бус байдлыг жил бүр үнэлнэ.
- d) Хороо нь дотоод аудитуудын сургалтад хамрагдсан байдлыг хянаж, мэргэшүүлэх хөтөлбөрийг баталж, хэрэгжилтэд хяналт тавина.
- e) Улирал тутам дотоод аудитын жилийн төлөвлөгөөний хэрэгжилт болон банкны эрсдэлийн төлөв байдалд гарсан аливаа томоохон өөрчлөлтийг хянаана.
- f) Хороо нь дотоод аудитын тайлан, өгөгдсөн зөвлөмж, ашиглан залилангийн асуудлыг хянан, зөвлөмж өгнө.
- g) Дотоод аудитын тайлангийн мөрөөр банкны удирдлагад өгсөн томоохон зөвлөмж болон хариу тайлбаруудыг хянаана.
- h) Хороо нь шаардлагатай гэж үзсэн асуудлаар Ерөнхий Аудитортой тогтмол тусгайлан уулзаж байна.
- i) Хороо нь жилд нэгээс доошгүй удаа Ерөнхий аудиторын ажлын гүйцэтгэлийг үнэлж, түүний жилийн цалин хөлс, ингэхдээ түүний мэргэшил, ур чадвар болон хэрэгцээ шаардлагыг банкны ижил төстэй чиг үүрэг бүхий нэгжтэй харьцуулан хяналт тавина.

D. Хянан нийцүүлэлт

- a) Хууль, эрх зүйн нийцлийн хяналтын үйл ажиллагаа болон удирдлагаас хийсэн шалгалтын үр дүнд илэрсэн асуудлын мөрөөр хийгдсэн ажилд хяналт тавина.
- b) Зохицуулагч байгууллага болон аудитын хийсэн шалгалт, ажиглалтаар илэрсэн асуудлуудыг хянаана.
- c) Дараах тогтолцоог бий болгоно:
 - i. Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, түүний хяналт болон аудитын асуудлаар банканд ирсэн санал, гомдлыг хүлээн авах;
 - ii. Нягтлан бодох бүртгэл болон аудитын сэжигтэй асуудлуудын талаар ажилтнуудын зүгээс нэрээ нууцалсан, нууц байдлаар мэдээлэл хүлээн авах.
- d) Компанийн ажилтнуудад Ёс зүйн кодексыг таниулах үйл ажиллагаа, түүний хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагааг үнэлэх.
- e) Нийцлийн үйл ажиллагааны тайлан, холбоотой асуудлаар удирдлага болон компанийн эрсдэл/нийцэл хариуцсан ажилтантай тогтмол хэлэлцэх, хяналт тавина.
- f) Банкны санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал болон хууль тогтоомжийн нийцэлтэй холбоотой үүсэх аливаа асуудлаар ТУЗ-д тайлагнах.
- g) Хорооны хариуцах асуудалд хамаарах санхүү болон хянан нийцүүлэлтийн чиглэлийн гол бодлогуудыг жил бүр хянаж, батлах.

E. Бусад

- a) Шаардлагатай бол гуравдагч байгууллагаас хууль эрх зүй, нягтлан бодох бүртгэл болон бусад үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ, туслалцаа авах.